



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 242

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар (Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газар)-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 71,723,412.00 (далан нэгэн сая долоон зуун хорин гурван мянга дөрвөн зуун арван хоёр) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу Дорнод аймгийн Гаалийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд, Дорнод аймаг дахь Гаалийн газрын дарга Б.Гэрэлт-Од нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137005387
14-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2023 оны ... дүгээр сарын ... өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
 ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ
 ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг /төгрөг/	Шилжүүлэн авах байгууллага
1	Ниссэн патрол У61 автомашин, улсын дугаар 37-37 ДОА	2012/2013	71,723,412.00	71,723,412.00	0.00	Дорнод аймаг дахь Гаалийн газрын Эрэнцэв дахь Гаалийн салбарт
Нийт дүн			71,723,412.00	71,723,412.00	0.00	